



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 01 сарын 18 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Г “Улаанбаатар хотын даатгал” ХХК-д 7  
жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын  
үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 12<sup>1</sup>.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 302 дугаар тогтоолоор батлагдсан “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам”-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар хотын даатгал” ХХК-д жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

2. Даатгуулагчдын хууль ёсны эрх ашгийг дээдэлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Улаанбаатар хотын даатгал” ХХК/М.Энхболд/-д үүрэг болгосугай.

3. Даатгалын салбараа нээгээгүй аймагт жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагааг аливаа хэлбэрээр эрхлэн явуулахыг “Улаанбаатар хотын даатгал” ХХК-д хориглосугай.

4. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар/С.Ганболд/, “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан албан журмын даатгалын хэлбэрийг нэмж бүртгэхийг Тамгын газар/Д.Нямцэрэн/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН